

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234729

ЧИНГИЙН ҮЕИЙН ХОЁР ХЯТАД ИХ БУУНЫ ТУХАЙД

Ж.Кара<sup>1</sup>

Орчуулсан: Б.Алтангүл, Т.Отгонтуул

Энэ зууны эхэн үед хятадын империализмын эсрэг хийсэн томоохон хэмжээний бослогын түүхэн гэрч бол Будапештийн цэргийн түүхийн музейд хадгалагдаж буй хоёр хятад их буу юм. Энэ хоёр их бууны түүх тухайн үеийн, өнөөдөр холбоо багатай Хятад-Европын харилцааны түүхийг өгүүлдэг.

1900 оны бослогын үеэр европын цэргүүд энэхүү хоёр их бууг дайны “олз” маягаар Европд авчирч хожим Будапешт дахь Цэргийн түүхийн музейд хүлээлгэн өгчээ.<sup>2</sup>

Хоёр их бууг Музейн төв хаалганы өмнө байрлуулсан бөгөөд хоёр дугуйтай их бууны суурин дээр 22, 23 гэсэн дугаар хаджээ. Хоёр буу нь хоёулаа хошуугаараа цэнэглэгддэг бөгөөд гол төмрүүд нь хүрэл<sup>3</sup>. 22 дугаартай их буу нь илүү том бөгөөд гол төмрийн калибр нь 14 см, урт нь 330 см. 23 дугаартай их буу нь 12 см-ийн калибртай бөгөөд 300 см.<sup>4</sup> Гал асаах нүхнүүдийг нь дөрвөлжин тавцангийн голд, түгжээний ойр байрлуулсан байна. Хоёр хажуу талд байгаа хөндлөн бариулаар тавцанг гол төмөртэй холбосон. Их буунуудын овоо хараа нь байхгүй болжээ.

Их буунуудын гол төмрийг хятад, европ маягийн товойсон, цагираг хэлбэртэй хээгээр чимэглэжээ. 22 дугаартай том их буу нь илүү их чимэглэлтэй байна. Бууны амнаас хойшоо ховилтой, цагирагт доорх элементүүд байна. Үүнд: эгнэсэн сувд (их бууны бөмбөгийг бэлгэдсэн хагас бөмбөрцөг хэлбэртэй), үргэлжилсэн

<sup>1</sup> G.Kara(1960), “Sur Deux Canons Chinois Des Ts’ing”, Acta Orientalia, Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 249-253.

<sup>2</sup> Музейн архивын баримт бичигт үндэслэсэн, цэргийн түүхийн музейн захирал, хурандаа Цсиллаг (Csillag)-ийн өгсөн мэдээлэл.

<sup>3</sup> Юань гүрний төгсгөл үеийн төмөр хятад их буунуудын тухай 馮家昇 *Fong Kia-cheng*, 火藥的發明和西傳 *Hou-yao ti fa-ming houo si-tch’ouan* (Бээжин 1954), хх. 41-43. Хятадын их бууны түүхийн тухайд, нэг ижил зохиогчтой, 回教國為火藥由 中國傳入歐洲的橋梁 *Houei-kiao-kouo wei houo-yao you Tchong-kou tch’ouon-jou Ngeou-tcheou ti kiao-leang*; 史學集刊 *Che-hio tsi-k’an*, 6 (Бээжин 1950), 古今國書集成 *Kou kin t’ou chou tsitch’eng*, 攻守諸器部 *Kong cheou tchou k’ipui*-тэй харьцуулах. – XVIII зууны хятад төмөр их бууны тухай А. Позднеев, Санкт-Петербургийн их бууны музейд хадгалагдаж буй хятад их буу (Китайская пушка, хранящаяся в Петербургском Артиллерийском Музее): ЗВОРАО I (1886), хх.121-126.

<sup>4</sup> Цэргийн түүхийн музейн бараа материалын мэдээлэл.

дэлбээ, төрөл бүрийн дэлбээтэй том, том цэцэгтэй, эгнэсэн сувд (цагираг дээр мөн байна)-тай. Хоёр талдаа гурван эгнээ хэвтээ солбисон сувдтай. Ховилтой ирмэгийн цагирагийн хоёр талд ижил хээ дүрслэл давтагдсан. Тэгээд дөрвөн дэлбээтэй жижиг цэцгийг дүрсэлжээ. Дугуй дунд нь (европ маягийн) эгнэсэн сувдтай бөгөөд хөндлөн гурван сувдан судалтай. Хоёр бөгжний дунд богино дэлбээтэй цэцгийг цувруулж гурвалж сул сүлжсэн. Бөгжний гадар нь иржгэртэй, босоо сувдан гурван эсрэгцсэн хоёр эгнээтэй, хоёр босоо хэсэгт нь нэг бөгжний үзүүрийг нь цэцгээр чимэглэсэн. Голд нь 12 дэлбээтэй том цэцгийг эгнүүлсэн бөгөөд акантусын навчийг ам руу нь харуулан өрж, үзүүрийг нь бөгжилсөн байна. Бөгжний үзүүрт Чингийн үеийн хүрэл чимэглэлийг дууриан хийсэн загварлаг лууг эгнүүлэн цагираг дунд нь бүдүүн тоймоор гурвалжилж оруулсан бөгөөд ховил, цагираг үргэлжлээд грек дүрсүүдийг зүүн тийш харуулж байрлуулжээ.

23 дугаартай их буу нь дөрвөн дэлбээтэй цэцгийн эгнээтэй бөгөөд голд нь цомирлогийн навчинцар, дэлбээ үргэлжлэн оржээ. Бөгжний ирмэг нь ховилтой, сувдыг пирамид хэлбэрээр эгнүүлж, хоёр цагирагны хооронд хэлхсэн тойргийг мөн эгнүүлж оруулсан. Үргэлжилсэн дэлбээн, бөгжин дээрх сувдан эгнээтэй. Хоёр талдаа зүрхэн хэлбэртэй навч, сувд, бөмбөлгөн эгнээтэй, мөн сараана цэцгийг санагдуулам цэцэг, сувд, цагираг, акантыг санагдуулам навчин эгнээтэй.

Хоёр их буун дээр 11 мөр манж, мөн тооны хятад бичээс байна. Их бууны зүүн талын цилиндрийн толгойн дээд талд манж бичиг, баруун талд нь хятад бичиг байрлаж байна.

**22-р их буун дээр манжаар ингэж бичжээ.**

1. *Daiçing gurun-i Elhe tayifin-i orin jaqôci<sup>5</sup>*
2. *aniya hungkerehe*
3. *çoron şanguyaça enteheme aqdun amba*
4. *jiyanggiyôn. Bayitalara oqto ninggun gin jaqôn [liyan]*
5. *eshun selei muçaliyan juwan ilan gin*
6. *sing-ni den uyun fun emu li*
7. *durun ilibuça çafan Nan çôwai-zin*
8. *tuwame weyilehe çafan Foboo*
9. *şostai*
10. *zoguwan Wang ji-çen*  
*Li Wen-de:*
11. *façsi da*  
*Yen Si:*

**22-р их буун дээр хятадаар ийн бичсэн байна.**

1. 大清康二十八年
2. 鑄造
3. 武成永固大將軍甲
4. 樂六觔八兩
5. 生鐵砲子十三觔
6. 星高九分一量
7. 製法官南懷仁

<sup>5</sup> Дайчин улсын Энх-Амгалангийн хорин наймдугаар он.

8. 鑄造官佛 保
9. 碩思泰
10. 作官王之臣  
李文德
11. 匠役  
顏 四

Хоёр их бууны бичээсэн дээр тоо л ялгаатай байна. 23-р их бууны бичээс дээр хэдэн ялгаатай мөр байгааг доор харуулав.

4. *jīyanggiyôn. bayitalara oqto sunja gin*
5. *eshun selei muhaliyan juwan gin*
6. *sing-ni den emu cun*

Хятадаар бичсэн бичээсэн дээр доорх мөрүүд ижил байна.

4. 藥五觔
5. 生鐵砲手十觔
6. 星高一寸

## 22-р их бууны манж, хятад бичгийн орчуулгыг доор сийрүүлэв.

“Дайчин (хят. *Ta ts'ing K'ang-hi*) гүрний Энх-Амгалангийн (*elhe tayifin*) хаанчилсан үеийн 28-р он<sup>6</sup>. Ялагдашгүй<sup>7</sup>, алдарт мөнхийн<sup>8</sup> хүчтэй Генерал.

Тэр их буу дарь ашигладаг, 6 *жин*, 8 *лин*; цутгамал төмөр бөмбөгтэй, 13 *жин*; тусгалын өндөр<sup>9</sup> нь 9 пүн 1 ли<sup>10</sup>. Эл төслийг санаачилсан албан хаагч бол *Nan xôwai-zin* (хят. *Nan Houai-jen*). Ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан албан хаагч бол *Foboo* (хят. *Fo Pao*), *Sostai* (хят. *Cho Sseu-t'ai*) нар юм. Харин *Wang ji-çen* (хят.

<sup>6</sup> 28-р он гэдэг нь Энх-Амгалангийн (Каньши) 1689 онтой тохирно. Н. Чанг, *Хятадын дүйцэлүүд: хятад хувилбарууд* № 24 (M.Tchang, *Synchronismes chinois: Variétés sinologiques*, 24, Changhai 1905), Шанхай 1905-ийг харах. -Манж бичвэрт нэг үг илүү: гүрний нэр болон хаанчилсан хугацааны дунд *gurun* гэдэг үгийг хамаатуулах тэмдэг үг шиг оруулжээ.

<sup>7</sup> Манж. *хорон šanggaha*~ хят. 武成 *wou tch'eng* гэдэг нь “баатарлаг үйл бүтээгч” гэсэн утгатай. Хауер, II, 457: *horon šanggaha enteheme akdun amba jiyanggiyun*, (мо:сүр хүч төгссөн ашид бат их жанжин. Т.О) “аймшигт сүр хүчийг авчрагч мөнхийн агуу жанжны буу”.

<sup>8</sup> Хятад их буунуудыг нэрлэдэг нэршил, Фонг-Киа-шенг (Fong Kia-cheng), *Houo-yao ti fa-ming houo si-tch'ouan*, х. 42. 銅將軍 *t'ong tsiang-kiun* « хүрэл генерал », 大將軍 *ta tsiang-kiun* « том генерал », 奪門將軍 *touo-men tsiang-kiun* « хаалгыг цоолдог генерал»-тай харьцуулах. Мөн Позднеев-ийн « Хятадын их буу », х. 124: 大將軍 *ta tsiang-kiun* « агуу генералын их буу »; Позднеевийн тодорхойлсон их бууг 彰武大炮 *tchan wou ta chen p'ao* буюу манж. *iletuleme horoloro amba ferguwecuke poo* « дайчин, агуу, гайхалтай их буу » гэж нэрийдсэн. -Манж хэлний *jīyanggiyon* гэдэг нь хятад хэлний *tsiang-kiun* гэдгийн эртний галиг бөгөөд, *jīyanggiyon*-ны далд эсрэгцсэн хэлбэр юм, Л. Лигети, *Манж бичгийн тухайд, Акта Ориент. Унгар.* II, х.285, 27-р зүүлттэй харьцуулах.

<sup>9</sup> Манж. *sing-ni den*, хят. 星高 *sing kao* « тусгалын өндөр » (星: 衡器上之識點也, 辭海 *Ts'eu hai* ба Иннокентиж, I, 808b: “кантара дахь цэгүүд”-тэй харьцуулах). Манжаар нийлүүлж бичсэн нь ялгаатай: эхнийх нь хятад хэлний *sing* гэдгээс зээлдсэн бол хоёрдах нь манж үг (Захаров энэ үгийг хятад гаралтай гэж бодоод алдаатай авч хэрэглэсэн). Энэ хоёр нэгдсэн үг хамаатуулах төгсгөлөөр холбогдсон байна.

<sup>10</sup> Манж хэлэнд байгаа *gin, liyan, fun, li, cun* гэдэг нь хятад хэлний *kin, leang, fen, li et ts'ouen* гэх нэр томъёоноос зээлдэж авсан хэлбэрүүд юм.

*Wang Tchou-tch'en*) гүйцэтгэсэн бол эзэд нь *Li Wen-de (Li Wen-te) et Yen Si (Yen Sseu)*<sup>11</sup> нар юм.

23-р бууны бичгийн хувилбарын орчуулга:

4-р мөрөнд “их бууны дарь, 5 жин, цутгамал төмөр бөмбөлөг, 10 жин”;

5-р мөрөнд: цутгамал төмөр бөмбөлөг, 10 жин” ;

6-р мөрөнд “тусгалын өндөр 1 лин

Бичвэр дээр гарч буй *Fo Pao* нэртэй хүн тухайн үед амьдарч байсан, Манжийн баруун талын цагаан туганд харьяалагддаг байсан *Fo Luen* гэдэг хүн байх магадлалтай. Энх-Амгалангийн үед цэргийн өндөр албан тушаал хашиж байжээ, 中國人民大辭典 *tchong-kouo jen-ming ta ts'eu-tien*, х. 303: 佛倫-тай харьцуулах.

*Cho Sseu-t'ai* гэдэг нь *Cho Tai*-тай ижил байж магадгүй, энэ тухай тодорхой сайн мэдэхгүй байгаа юм. *Cho Tai* гэдэг нь Манжийн баруун талын цагаан туганд харьяалагддаг байсан бөгөөд Ү Саньгүй (*Wou San-kouei*)<sup>12</sup>-ийн болон бослогыг дарах болон Галдангийн эсрэг тулаанд оролцож явсан, энэ ажил дээр дурдсан, х.1365: 碩岱-тай харьцуулах.

*Nan Houai-jen* гэдэг нь Фердинанд Вербиест (Ferdinant Verbiest 1623-1688) гэдэг Иезуитийн номлогч, Энх-Амгалангийн (Канг-Ши-ийн) ордонд одон орон судлаач, математикчаар ажилладаг байсан бельги хүний хятад нэр гэдгийг та бид бүгд мэднэ. Түүнийг 1674 онд дэлхийн газрын том зургийг хятадаар хэвлэсэн гэж үздэг бөгөөд *Tatar хэлний элементүүд* зэрэг<sup>13</sup> бүтээлийн зохиогч юм. А. Фабиерийн *Бээжин, Түүх, тодорхойлолт* (Лилль 1900) нэртэй бүтээлд түүнийг их бууг үүсгэн байгуулагч хэмээн ийн бичжээ. “Эзэн хаан олон дахин оролдож үзээд, их буу хэрэглэхгүйгээр Ү Саньгүй (*Wou San-kouei*) эзлэх боломжгүй юм байна гэдгийг ойлгодог. Гэтэл их бууны их бие нь төмрөөр хийсэн тул маш хүнд, эгц цавчим уул руу түүнийг хүргэж чадахгүй байв. Тэгээд Ф. Вербиест тэр дутагдалтай талыг янзалж дөнгөх байх гээд их бууны хүнд хэсгийг нь европ загвараар хөнгөн болгохыг тушаатал нөгөө номлогч чадахгүй гэжээ. Гэтэл дайснууд нь математикийн аргаар тооцон их бууг хайлуулан хийхэд ямар ч

<sup>11</sup> *Foboo, Wang Ji-cen, Li Wen-de, Yen Si* гэдэг нь хятад эхээс нь оноож буулгасан манж хувилбар юм. *Sostai* гэх нэрэн дээр л ялгаа харагдаж байна. Гурван үетэй хятад нэрийг манж хэлээр галиглахдаа хоёр үетэй болгожээ. - 匠役 *tsiang i* (Innokentij, II, 468b: “төрийн ажилчид”; Мэттьюс, №662: “төрд албадан ажиллагсад) гэх хэлцийн хувьд манж. faqsi da~хят. 工師 *kong-che* “ахлах хянагч” (Хауэр, I, 270)-тэй харьцуулах.

<sup>12</sup> Саньгүй(1612-1678) Мин улсын цэргийн жанжин, ван бүлгээ. Манж нар Бээжинг эзлэн Хятадад ноёрхлоо тогтооход Чин улсад зүтгэн гавьяа байгуулсан тул өрнийг төвшитгэгч пин шиван хэмээн өргөмжилж, Юньнаньд суулгаж байв. Тэр бээр V Далай ламтай найрсаг харилцаатай байсан аж. 1673 онд түүхэнд харьяат гурван вангийн бослого (Ү Саньгүй, Гэн Жинжун, Шан Жишин гурван жанжинг хэлж буй) гэж нэрлэгдсэн Чин улсын эсрэг бослогыг дэгдээн гол удирдагч нь болжээ. 1673-1675 онд бослого ихээхэн газар авч, Хятадын арван нэгэн мужийг хамарч байв. Бослогын гол төв бөгөөд анх эхэлсэн Өмнөд мужуудад тэмцэл үндсэндээ 1679 онд дарагдсан боловч, Сычуань, Хунаньд 1681 он хүртэл үргэлжилжээ. Босогчид Жоу улсыг (1678-1681 он) тунхаглан Ү Саньгүйг Тайзу хаанаар нэхэн өргөж байжээ. (Т.О)

<sup>13</sup> Фавие, Бээжин, хх. 154, 159-162; Х. Алениус, Хэв: Шаванн: *Тонг Пао IV*, hh6 418-419; Б. Лауфер, *Манж уран зохиолын дээж*: Келети Сземле IX, х. 51; П. Пеллио, “*Tatar хэлний элементүүд*”-ийн *жинхэнэ зохиогч*”: *Тонг Пао XXI*, хх. 367-386; Бадделэй, *Орос, Монгол, Хятад*, II, хх. 433-435; Лигети Л, Унгарчуудын тухай бичсэн XVIII зууны хятад бүтээл: Көрөш Чома нийгэмлэг (1935-39), х. 132.

асуудалгүй хэмээн Эзэн хааныг ятгажээ. Харин Ф. Вербист босогчидтой нууцаар тохиролцжээ, үгэнд нь орохгүй бол амь нас, шашин нь аюулд өртөнө гэдгийг Энх-Амгалан (K'ang-hi) түүнд ойлгуулжээ”.

...“Тэр бүх чадлаараа их бууг сайжруулж, Эзэн хааныг харж байхад их буунууд нь дайнд маш сайн буудсан тул эзэн хаан ихэд баярлаж ордондоо авчирч олны өмнө сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж булган дээлээ тайлж өмсгөжээ”. (х.161.)

Вербист-ийг таалал төгссөний (1688 оны 1-р сарын 29) дараа ч гэсэн түүний төслийн дагуу их буу үйлдвэрлэдэг байсныг эдгээр хоёр их бууг харсан гэрч өгүүлсэн байдаг.

Будапештийн Цэргийн түүхийн музейд хадгалагдаж буй энэхүү хоёр хятад их буу Чингийн үеийн хятад-европын харилцааны сонирхолтой гэрч болж байгаа бөгөөд Иезуитийн хүндэт гишүүн Фердинан Вербист-ийн бүтээлийг нэг их тоомжиргүй ханддаг байсан хэдий ч энэхүү харилцаанд гол үүрэг гүйцэтгэдэг байсан нь харагдаж байна.



Их буун дээрх манж бичээс



**Гэрэл зургийн эх сурвалж:**

[https://commons.wikimedia.org/wiki/File:K%C3%ADnai\\_kerekes\\_%C3%A1gy%C3%BA\\_%28Ny%29.\\_-\\_Kapisztr%C3%A1n\\_t%C3%A9r,\\_2016\\_Budapest.jpg](https://commons.wikimedia.org/wiki/File:K%C3%ADnai_kerekes_%C3%A1gy%C3%BA_%28Ny%29._-_Kapisztr%C3%A1n_t%C3%A9r,_2016_Budapest.jpg)